

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэг
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСАТАГ-2019/23/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Чойр хот)

2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 70543156

Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Утас: 70543179

Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn

Аудитор: Д.Оюунбат

Утас: 70543179

Цахим хаяг: ouuna200702@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зерчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11-14
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	15-23



ГОВЬСҮМБЭР АНГААГ ДАХЬ
ГОРНИЙ АУДИТЫН ГАЗАР

12015 Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 3 дугаар бүлэг

Утас: 7711-7000-2003 2172

И-мэйл: govsub@ministry.gov.mn

ШИВЭЭГОВЬ СУМЫН 3 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Б.ДАВААДОЛГОР
ТАНАА

2019.02.25 № 43

танай

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын дотоод хяналт хангалтгүй, өмнөх аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргасан, төсвийг үр ашиггүй

зарцуулсан, тайлант оны жилийн эцсийн бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй, тооцоо бодож актаар баталгаажуулаагүй зэрэг материаллаг хэмжээний алдаа илэрсэн тул бараа материал дансны хамрах хүрээг хязгаарлаж, дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дахь заалт, санхүүгийн тайлангийн "оршин байх", "эрх ба үүрэг", "иж бүрэн байх", "үнэлгээ", "толилуулга ба тодруулга", "үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн захирагч Б.Даваадолгорт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг" -ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.15-наас 2019.02.22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, "Саруул баян уул- аудит" ХХК-ийн аудитор Д.Оюунбат хариуцаж хэрэгжүүлэв.

Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг "Саруул баян уул-аудит" ХХК-д 2019.01.21-ний өдрийн 21 дугаар бичий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн "Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, сургуулийн өмнөх боловсрол олгох" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Боловсролын тухай хуульд заасны дагуу Сүмбэр сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн үйл ажиллагааны чиглэл нь "Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа" гэж тодорхойлсон байна.

Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- ХХОАТ-ын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Гүүк софт" ХХК-ийн "AXPLORER" програм хангамж ашиглаж байна.

Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "бага" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт "үр нөлөөгүй" гэж үзлээ.

Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл хөтлөөгүй, няравын тайланг нягтлан бодогч тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр "Нийт зардал"-ын 1 хувиар сонгов.

"Нийт зардал"-ыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь материаллаг байдлын суурийг нийт орлогоос тооцоход үлдэгдлийг төсөвт төвлөрүүлдэг буюу байгууллагын үйл ажиллагаанд бүрэн зарцуулагддаггүй, нийт хөрөнгийн дүн өндөр байгаа тул нийт зардлыг суурь болгон сонгох нь зохимжтой гэж үзэв

Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн 2018 оны нийт зардал 422,177.2 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 4,221.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь өмнөх аудитаар зөрчилгүй дүгнэлт авч байсантай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	14,116.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	646.0	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	5	14,762.1	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв: Үүнд:

2.8.1.1 Ээлжийн амралттай холбоотой асуудал

Тайлант онд ажиллагсдын ээлжийн амралтын тооцоог хянаагүйгээс 4 ажилтанд нийт 478.0 мянган төгрөгийн цалинг, ээлжийн амралтын цалинтай давхардуулан олгожээ.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Ээлжийн амралт олгох заавар"-ын 13-т заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт бичив.

2.8.1.2 Ээлжийн амралттай холбоотой асуудал

Тайлант онд үндсэн бус нягтлан бодогч П. Пүрэвнямд мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтанд хамрагдсан сургалтын төлбөрт 168.0 мянган төгрөг төлсөн боловч ямар нэгэн хариуцлагын гэрээ байгуулаагүйгээс нягтлан бодогч ажлаасаа чөлөөлөгдсөн тул төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт бичив.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд анхаарал татахуйц асуудал илрээгүй болно

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 402,903.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсөвт зардлын гүйцэтгэл 402,896.2 мянган төгрөг буюу 100.0 хувь зарцуулсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн санхүүжилт 402,903.7 мянга, нэмэлт санхүүжилтийн 1,710.1 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 4,545.0 мянга, бараа материал 1,260.0 мянга, ҮОМШӨ-ийн хөнгөлөлт 277,1 мянга, нийт 410,695.9 мянган төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн санхүүжилт 402,903.7 мянга, нэмэлт санхүүжилтийн дансаар 1,710.1 мянга, нийт 404,613.8 мянган төгрөгийн төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулсан байна.

Оны эхэнд 545.6 мянган төгрөгийн авлагатай, өглөггүй байсан ба оны эцэст авлагагүй, 215.3 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан байна. Өглөг өссөн нь нягтлан бодогчийн тооцоололтой холбоотой байна. Тухайлбал: цалин, НДШ-ийн тооцоог тухай бүр хийгээгүйтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд сумын ОНХС-аас үндсэн хөрөнгөд 4,545.0 мянга, бараа материалд 1,260.0 мянга, нийт 5,805.0 мянган төгрөгийн гэр, ор, зөөлөн эдлэл хүлээн авч бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний үр дүнгээр, дахин үнэлгээний нэмэгдэл данс 53,552.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, үнэлгээний бууралтаар 84,180.6 мянган төгрөгийг тайлант жилийн зардлаар бүртгэсэн байна.

Мөн байгууллагын эзэмшилд байгаа газар 15,470.0 мянган төгрөгөөр үнэлэгдэж, биет бус хөрөнгийн дансанд бүртгэж, засгийн газрын сангаа нэмэгдүүлсэн байна.

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр 79,427.7 мянга, сумын ОНХС-аас 1260.0 мянга төгрөгийн зөөлөн эдлэл, нийт 80,687.7 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч, 83,133.4 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулж, эрхлэгчийн 2018.12.21-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар 615.4 мянган төгрөгийн бараа материалыг акталж, оны эцэст 31,139.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг" -ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллийн 2 нь хугацаа болоогүй, хугацаа хоцорч оруулсан мэдээлэл 1 байна.

Цаашид шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулан ажиллах нь зүйтэй.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувьтай байна.

3.3 Тооллого, тооцоо бодолтын талаар

Илрүүлэлт

Бараа материалын тайланг шалгаж, тооцоо бодсон акт үйлддэггүй, жилийн эцсийн 12,964.8 мянган төгрөгийн бараа материалыг тоолсон эсэхийг нотлож чадаагүй болно.


Энэ нь "үнэн зөв байх", "тохиолдсон байх", "оршин байх" гэсэн батламж мэдэгдлүүдэд нийцээгүй бөгөөд НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

Бараа материалын тайланг шалгаж, тооцоо бодсон актаар баталгаажуулж, тоолсон үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулган шалгаж байх

Хариуцах ажилтан

Дарга
Нягтлан бодогч


Б.Даваадолгор
О.Дөлгөөн

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Эрсдэл

Хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйгээс удирдлага, нягтлан бодогч нар хариуцлага хүлээх эрсдэлтэй

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

СТ-1А

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		<u>34,745,973.72</u>	<u>31,139,286.72</u>
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		
34	УРЬДЧИЛГАА	545,652.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	545,652.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	34,200,321.72	31,139,286.72
354	Хангамжийн материал	34,200,321.72	31,139,286.72
35410	Бичиг хэргийн материал	279,120.00	279,120.00
35420	Аж ахуйн материал	16,113,896.00	18,174,516.00
35450	Барилгын засварын материал	11,500.00	11,500.00
35460	Хүнсний материал	10,603,055.00	5,481,400.00
35470	Бусад хангамжийн материал	7,192,750.72	7,192,750.72
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>366,573,840.80</u>	<u>343,540,892.61</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	366,573,840.80	343,540,892.61
392	Биет хөрөнгө	366,232,383.05	327,837,434.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	394,001,207.80	281,868,060.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(59,554,435.58)	16,796.83
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	34,906,720.00	34,906,720.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,511,265.80)	(26,896,355.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,668,095.45	22,668,095.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,872,273.24)	(18,224,156.64)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,818,818.20	2,828,818.20
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,591,015.00	46,697,222.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,815,498.78)	(16,027,765.87)
393	Биет бус хөрөнгө	341,457.75	15,703,457.78
39301	Програм хангамж	1,020,000.00	1,020,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(678,542.25)	(786,542.22)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	15,470,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>401,319,814.52</u>	<u>374,680,179.33</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>215,047.70</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	215,047.70
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	215,047.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>401,319,814.52</u>	<u>374,465,131.63</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	401,319,814.52	374,465,131.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн	274,888,229.31	194,481,419.09
51101	Өмч: - төрийн	316,223,656.51	331,693,656.51
512	Хуримтлагдсан үр дүн	(41,335,427.20)	(137,212,237.42)
51210	Өмнөх үеийн үр дүн	(41,335,427.20)	(41,335,427.20)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(95,876,810.22)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	126,431,585.21	179,983,712.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>401,319,814.52</u>	<u>374,680,179.33</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	403,165,100.00	410,695,986.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,000,000.00	6,082,159.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,000,000.00	6,082,159.00
120009	Бусад орлого	-	277,159.00
122	Тусламжийн орлого	7,000,000.00	5,805,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	7,000,000.00	5,805,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	392,966,600.00	404,343,827.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	392,966,600.00	402,903,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	392,966,600.00	402,903,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,440,127.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас доод шатад	-	1,440,127.00
131105	Төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлого	3,198,500.00	270,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	402,835,321.22	422,392,228.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	402,835,321.22	422,392,228.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	379,382,121.22	408,663,288.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,345,655.00	250,106,855.49
210101	Үндсэн цалин	169,491,622.00	181,173,653.49
210102	Нэмэгдэл	39,538,368.00	46,214,009.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	15,315,665.00	22,719,193.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал шимтгэл	24,115,352.00	29,994,978.21
210201	Тэтгэврийн даатгал	15,937,832.99	20,809,394.91
210202	Тэтгэмжийн даатгал	1,774,838.35	1,984,039.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,218,547.94	2,480,049.46
210204	Ажилгүйдлийн даатгал	380,375.70	429,226.75
210205	Эрүүл мэндийн даатгал	3,803,757.02	4,292,267.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,698,000.00	28,958,047.00
210301	Гэрэл, цахилгаан	5,292,119.00	6,217,314.00
210302	Түлш, халаалт	12,865,158.00	14,337,400.00
210303	Цэвэр, бохир ус	5,540,723.00	8,403,333.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,062,894.08	9,146,993.00
210401	Бичиг хэрэг	1,294,464.00	3,241,650.00
210402	Тээвэр, шатахуун	1,926,000.00	1,960,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	444,036.00	587,713.00
210404	Ном, хэвлэл	90,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,999,500.00	77,000.00

Шивээговь сумын "3 дугаар цэцэрлэг"-ийн 2048 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	3,280,630.00
210408	Бараа материал акталсны зардал	4,188,894.08	-
2105	Нормативт зардал	73,706,745.00	73,468,255.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	208,600.00	199,700.00
210502	Хоол, хүнс	72,901,245.00	73,130,055.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	596,900.00	138,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,922,400.00	1,940,700.00
210604	Урсгал засвар	4,922,400.00	1,940,700.00
2107	Томилолт, зочны зардал	607,500.00	578,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	607,500.00	578,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,280,100.00	793,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	560,100.00	76,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	651,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	66,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,643,475.14	13,676,160.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,649,500.00	1,078,652.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,549,000.00	168,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,444,975.14	12,429,508.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,453,200.00	13,728,940.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,453,200.00	13,721,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан	12,712,800.00	13,721,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,740,400.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	7,540.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,540.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	329,778.78	(11,696,242.96)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	84,180,567.26
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	84,180,567.26
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	329,778.78	(95,876,810.22)